



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 361/Н0370220

Эрдэнэбулган сум

099-2025/02/НА-ОДА-З/ГС

Г Зөрчил арилгах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Архангай аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй, аудитын гүйцэтгэх хугацааг хязгаарласнаас уг тайланд тусгасан 135,911,737.1 төгрөгийн зардлыг материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлсэн талаар аудитын хангалттай зохистой, нотлох зүйл олж авах боломжгүй, аудитыг хуулийн хугацаанд чанартай гүйцэтгэх, санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нөхцөлөөр хангаагүй болно.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д “төсвийн төвлөрүүлэн захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4.1-д “... төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Зөрчлийг таслан зогсоож, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж тайлагнах арга

хэмжээ авч ажиллан биелэлтийг 2025 оны 07 дугаар сарын 20 - ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гэрэлчимэг, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга Ц.Булганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Т.БАЙГАЛМАА
Н.АЛТАНТУЯА
Л.СОЁЛМӨНХ

0517143960
НО40052 9001034

¹Мангал Улаан, Архангай аймаг, Эрдэнэбүрэн сум, Зүйншилгээнд, 2025 онд бий болсан Улаан 70222210



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 360/00370220

Эрдэнэбулган сум

АРА - 2025/02/ИА - ОТА - ЗГС

Г Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд баланс бүртгэлтэй 3-аас дээш жилийн насжилттай нийт 5,617300 төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохицой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх

2 Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын газрын дарын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гэрэлчимэг, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга Ц.Булганчимэг нарт даалгав.

АЛБАНШААРДЛАГАӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Т.БАЙГАЛМАА
Н.АЛТАНТУЯА
Л.СОЁЛМӨНХ